БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА Ж.АЛТАНГЭРЭЛ

2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр

НАЛАЙХ ДҮҮРЭГ, 6 ДУГААР ХОРООНЫ НЭГ ЦЭГИЙН БАРИЛГЫН ГАДНА ХАНЫГ ЗАСВАРЛАХ АЖИЛ

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 17/03 дугаар тогтоол
2	Барилга байгууламжийн байршил	Налайх дүүрэг, 6 дугаар хороо, Тэрэлж
3	Барилга байгууламжийн зориулалт	Хорооны нэг цэгийн барилга
4	Барилгын давхар	2 давхар /зоорьтой/
5	Ажлын тоо хэмжээ	Гадна хананд 341.34м2 талбайд 100мм-ийн зузаантай хөөсөнцөр полистрол хавтангаар дулаалга хийх
6	Гадна заслын ажил	Барилгын булангуудад цонх, хаалганы орчимд 50мм-ийн зузаантай хөөсөн шахмал полистрол материалаар 2үе ам даруулан нааж, тэлэгчтэй дюбель хадаасаар ирмэгээс нь 10см дотор, хадаас хоорондын зай 40см Т хэлбэрээр бэхэлж тогтооно. Хаалга, цонхны уулзвар хэсэгт дулаалгын материалыг нэг шулуунд бус ам даруулж дулааны урсгалыг хааж угсрах Цокол хэсэгт дулаалгын зузаантай ижил хэмжээтэй тулгуур төмрийг 1м-ийн зайтай хадаасаар тэгш бэхлэнэ. Тэгш бус гадаргуутай хэсэгт хуванцар жийрэг буюу тэгшлэгч хийж өгнө. Хөөсөн шахмал полистрол хавтан дээр полиропилен (Хуванцар материал) тор бүхий цавуут зуурмагийг 10см-ийн зөрүүлэн хийнэ. Хаалга, цонхны ирмэг хэсгүүдэд нэмэлт булан торуудыг хийнэ. Тор нааж цавууг хатсаны дараа хөрсжүүлэгч хийж өнгөлгөөний шавардлага, зориулалтын фасадны эмульс будгаар өнгө гаргаж будна. /Будгийн өнгийг захиалагчтай зөвшилцөнө/
7	Аюулгүй байдал	Барилга байгууламж барих, ашиглах үеийн галын аюулгүй байдлыг хангаж, барилгын бүтээцэд галд тэсвэртэй материал ашиглах, гал унтраах хэрэгслийг тусгах Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журмыг мөрдөх
8	Гүйцэтгэгч	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиар
9	Хэрэгжүүлэх хугацаа	Захиалагч болон гүйцэтгэгч талуудын байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг үндэслэнэ.
10	Ажил гүйцэтгэх	Барилгын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын барилгын техникийн дотоод хяналтын дүрмийг мөрдөх

		Барилгын гадна ханын шавардлагатай дулаан тусгаарлалтын ажлын техникийн дүрэм /БД 12-103-07/-ийг мөрдөх

Захиалагч байгууллага:

- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг баримтлана.

Гүйцэтгэгч байгууллага:

- Ажил эхлүүлэхдээ дүүргийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, ажил гүйцэтгэх үе шатны график төлөвлөгөөг хүлээлгэн өгөх
- Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг мөрдөх
- Барилга, замын гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага /UCS0001-01:2019/-ыг мөрдөж ажиллах
- Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх
- Чанаргүй гүйцэтгэсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагч болон захиалагчийн хяналтыг төлөөлөн гүйцэтгэх эрх бүхий этгээдийн заасан хугацаанд засварлаж хүлээлгэн өгөх
- Барилгын талбайгаас гарах хаягдлыг зайлуулахдаа “Налайх Тохижилт Үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай хог тээврийн гэрээ байгуулан зөвшөөрөгдсөн хогийн цагт хог хаягдлыг хаях

Дээрх ажлын даалгаварт заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч болон захиалагчийн хяналтыг төлөөлөн гүйцэтгэх эрх бүхий этгээд, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Боловсруулсан: Хот төлөвлөлт, барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн Б.Галмөнх